

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ  
СОНГОХ ТУХАЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Р.Гончигдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа тус Байнгын хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт тус тус заасныг баримтлан Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцлээ.

Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын эвслийн бүлэг”-ээс Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг сонгуулахаар нэр дэвшүүлснийг тус Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар сонгуулахаар нэр дэвшүүлсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА -г



Ц.ЦОЛМОН